Европын Switch-Asia хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын байгалийн нөөцийг тогтвортой ашиглах 3R” – 3R4UB (2020–2025) төсөл нь Итали, Монголын хамтын ажиллагаагаар хотын хатуу хог хаягдлыг тогтвортой, дахин ашиглах чиглэлээр анхны туршлага солилцсон төсөл юм. Энэхүү төсөл нь судалгаа, мэдлэг, зөв дадал, техникийн сургалт, иргэний оролцоо зэрэг үйл ажиллагааг хослуулан хэрэгжүүлж, орон нутгийн чадавхийг бэхжүүлэх болон Монгол улс дахь түнш байгууллагуудыг стратегийн зорилго хэрэгжүүлэх, үр чадвараа хөгжүүлэх, санхүүжилтийн бодлогыг бие даан хэрэгжүүлэх чадвартай болгоход хувь нэмэр оруулах зорилготой юм. Энэхүү төсөл нь хотын хатуу хог хаягдлын менежментийг тухайн салбар төлөвлөлтийн уламжлалт арга барил болон зохион байгуулалтын дэвшилтэт туршлагыг хослуулсанаараа өвөрмөц онцлогтой. Төслийн хэрэгжилт нь Монголын соёл, нийгмийн бүтэц, иргэдийн дадал зуршилд онцгойлон анхаарч, үүний дагуу төслийн удирдлагын төлөвлөгөө болон орон нутгийн техникийн чадавхийг тухайн нөхцөлд тааруулан гаргасан болно. 3R4UB төслийн хүрээнд Итали-Монголын түншлэл ердөө дөрөвхөн жилийн хугацаанд хотын хатуу хог хаягдлын менежмент болон холбогдох байгаль орчны асуудлуудад шийдвэрлэх арга барилыг боловсруулан ажиллажээ. Төслийн хүрээнд тухайн төсөл хэрэгжих газрын бодлогын талаарх

мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдгээрийн үр ашиг, үр нөлөөг сайжруулах зорилготойгоор иргэдийн оролцоог байнгын нэмэгдүүлэх зорилготой зорилтыг боловсруулсан болно. Энэхүү гарын авлага нь төслийн хүрээнд хийсэн ажлыг илүү хялбар, ойлгомжтой байдлаар иргэдэд хүргэх зорилготой. Гарын авлага нь төслийн техникийн агуулгыг алдагдуулахгүйгээр, төсөлтэй холбоотой мэдээлэл авахыг хүссэн хүн бүхэнд зориулагдсан болно. Мөн байгаль орчны асуудалд анхаарал хандуулж, нийгэмд тулгарч буй асуудлуудыг шийдэхэд идэвхтэй оролцохыг хүсэж буй хүмүүст зориулсан болно. Энэхүү гарын авлага нь төслийн зорилт болон ололт амжилтыг хялбар, ойлгомжтой аргаар дамжуулж танилцуулахад оршиж байгаа бөгөөд энд дурдсан таван зааварчилгаа болох гарын авлагууд нь төслийн гол зорилтуудыг болон түншүүдийн хоорондын хамтын ажиллагааг онцлон харуулахад чиглэгдсэн. Төслийн хамгийн чухал үр дүн нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд оролцсон бүх түнш, байгууллагууд болон иргэд билээ. Үүнд: салбар бүрийн мэргэжилтнүүд, холбогдох байгууллагуудын албан тушаалтнууд болон техникчид (Монголын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Улаанбаатар хотын захиргаа), багш нар болон сурагчид мөн Монголын дахиврын бизнес эрхлэгчид зүй ёсоор орно. Төсөлд оролцсон салбар бүрийн оролцогчид нь төслийн явцад өөр өөр зорилготой оролцсон ч бүгд төслийг хэрэгжүүлэх туршид төслийн

тавьсан зорилтын дор нэгдэн оролцсон юм. Энэ нь төслийн онцлог болон нэгдсэн үзэл бодлыг илэрхийлж байна. Төслийн гарын авлага нь маш тодорхой, энгийн ойлгомжтой аргаар бичигдсэн. Гарын авлагууд нь төслийн хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааг тайлбарлах, тухайн төслийн үргэлжлэх хугацаа, ажиллах арга барил, мөн төслийн явцад тулгарсан зарим бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар зөвлөмжүүдийг өгөх зорилготой. Гарын авлага бүрд төслийг хэрхэн хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх явцад хэрэглэсэн арга барилын тухай тайлбар болон зааварчилгаа орсон болно.

Энэхүү 5 гарын авлага нь төслийг илүү олон хүнд хүргэхэд туслах, хатуу хог хаягдлын менежмент, төлөвлөгөө, зорилтыг ойлгоход дэм болох мөн практик зааварчилгаа болон үлдэх боломжтой. Түүнчлэн ирээдүйд бидний эхлүүлсэн замыг цааш нь үргэлжлүүлэх олон хүн байгаасай хэмээн хүсч тэдэнд замынх нь эхлэл нь байх болтугай гэж найдаж байна.





3R4UB

Reduce - Reuse - Recycle



Зааварчилгаа №1 / Лого болон түүний график зураглал, дизайн

Пиктограм ашиглах:

Түвшин: Дунд

Хугацаа: 6 сар

Шаардлагатай мэргэжлийн үр чадвар: График дизайны мэргэжлийн үр чадвар, Харилцаа, холбооны нарийн мэдлэг

Үндсэн элементүүд:

- * Концепц
- * Нэршил
- * Логоны стандарт
- * Өнгө ба фонт (типографи)
- * Пиктограмм
- * Гарын авлага

Олон улсын хамтын ажиллагааны төслийг сурталчлах явцад гол анхаарах зүйл нь олон талт хэрэглэгчид буюу нийгэм, соёлын хувьд ялгаатай оролцогч талуудын дунд ойлгомжтой, уялдаа холбоотой, итгэл төрүүлэхүйц байх юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд логоны график дизайны нарийн төлөвлөлт болон тухайн лого стандартад нийцсэн байхыг чухалчлах хэрэгтэй.

Эхний алхам:

Лого нь таних тэмдэг төдийхөн бус бөгөөд тухайн төслийг танилцуулах стратегийн чухал агуулгатай. Лого нь зөвхөн гоо зүйн хувьд үзэмжтэй байхаас гадна,

төслийн үнэт зүйлс, зорилго, алсын хараа, мөн чанарыг илэрхийлж байх ёстой. Иймд лого бүтээхээс өмнө, логогоор дамжуулан хүргэх гол мессежийг тодорхойлох, уг мессежийг (аль болох товч, ойлгомжтой, хэт техникийн нэршлээс зайлсхийх) төслийн үнэт зүйлс болон стратеги, шинж чанартай уялдуулж бусдад ойлгомжтой хүрэхэд анхаарах.

Ажилын явц:

Төслийн гол утга санаа, зорилтод тулгуурлан нэр оноох. Товч тодорхой, эерэг утга санааг агуулсан амархан цээжлэгдэхээр байх.



Визуал концепцийг тодорхойлох: Логог төслийн мөн чанар, зорилт, хэтийн төлөв болон тухайн хэрэгжүүлж буй улсын соёлын онцлог, шинж чанартай хослуулан тодорхойлох. Логоны харагдах элемент бүрийг нарийвчлан тооцоолох. Сурталчилгааны бүхий л төрлийн самбарын орон зайг зөв ашиглахаар тооцоолон логоны бүх элементүүдийг танигдахуйц байхаар хэвтээ болон босоо 2 төрлийн график загварыг гаргана. Пиктограмм буюу зурган дүрслэл нь хэрэглэгчдэд нарийн төвөгтэй мэдээллийг хурдан ойлгоход туслах зорилготой харилцааны ухаалаг шийдэл юм. Логоны график загварыг гаргасны дараа логоны элемент бүрийг тайлбарласан гарын авлага гаргах нь зүйтэй.

3R4UB төслийн лого дараах утга, мөн чанарыг агуулах шаардлагатай.

- Шууд танигдах: Хэрэглэгчид төслийн логог хаана ч харсан амархан танигдахаар байх. Үүнд дараах харилцаа холбооны хэрэгслүүд орно. (мэдээллийн брошур, веб сайт, нийтийн тээвэр, сурталчилгааны самбараас илүүтэйгээр хог хаягдал ангилан ялгах савнууд дээр байрлуулахад анхаарах)
- Тодорхой: Лого нь зөвхөн харагдах байдлаас гадна иргэдэд төслийн хэрэгжилтэнд оролцоход тусалж зааварчилгаа өгөн, оролцоог нь дэмжих зорилготой.
- Итгэл, үнэмшил төрүүлэх: Мэргэжлийн түвшинд хийсэн, чанартай лого нь төсөл хэрэгжих бүхий л орчинд олон давтамжтайгаар харагдсанаар иргэдийн төсөлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, хог хаягдлыг ангилан хаяхад оролцоог нэмэгдүүлдэг.
- Хамтын оролцоо: Лого зөвхөн гоо зүйн үзэмжээс гадна бүх иргэдийг тэгш эрхтэйгээр хамтран ажиллахыг илэрхийлэх үүрэгтэй. 1р хэсэг төгсөв.

Товчхондоо:

Лого нь тухайн хэрэгжүүлж буй улсын соёлын онцлогт тулгуурлан төслийн мөн чанар болон төсөлд оролцож буй иргэдийг илэрхийлэх элемент юм. Лого нь өнгө, фонт, элементүүдээр дамжуулан тухайн төсөл хэрэгжиж буй улсын нийгэм, соёлыг харуулах мөн төслийн гол зорилгыг харуулах чухал үүрэгтэй. Эцэст нь хэлэхэд төслийн лого нь харилцаа холбоо, мэдээллийн гол уялдаатай хэрэгслийн нэг юм.




3R4UB төслийн хувьд лого нь тогтвортой хөгжил, хариуцлага, ирээдүйг харуулах үүрэгтэй. Логоны нэршил нь төслийн нэршлийн товчлолыг илтгэхээс гадна ариглах, ангилах, ашиглах гэсэн хог хаягдлын тогтвортой хөгжлийн утгыг агуулах нь зүйтэй юм. Визуал концепт нь энгийн, ойлгомжтой график элементүүдийг (байгалийн элемент, хог хаягдлын ангилан ялгах тэмдэгт, 2 гарын алгаа дэлгэн хайрлан, хамгаалж буйг илтгэсэн тэмдэгт г.м) агуулсан байх хэрэгтэй бөгөөд ялангуяа Монгол улсын соёлын хэв шинжид тулгуурласан соёлын бэлэгдэл элементүүдтэй хослуулан бүтээх хэрэгтэй юм. Логог хийхдээ дугуй болон тэгш өнцөгт хэлбэрийг голчлон ашиглах нь зүйтэй. Эдгээр дүрс нь төслийг танилцуулах төрөл бүрийн хэвлэмэл материалд (жижиг брошур, плакат, вэб танилцуулга, замын хогийн сав, тээврийн хэрэгсэл) томруулж, жижгэрүүлэхэд хэмжээ болон шинж чанараа алдахгүй төлөвтэй. Логог бүтээхэд хог хаягдал ангилан ялгахад хэрэглэдэг классик өнгөнүүдээс сонгон авах нь зүйтэй бөгөөд бүх төрлийн хэвлэмэл материал, мэдээллийн самбар болон хогийн саванд хэвлэхэд тохиромжтой, уншихад хялбар үсгийн фонт сонгох нь чухал юм. Төслийн талаарх зар сурталчилгаа нь иргэдийг хотын захиргааны журам болон хүнсний сав, баглаа дээрх зааврын дагуу хог хаягдлыг зөв ангилан ялгахад туслан чиглүүлэх үүрэгтэй юм.

ЗӨВЛӨГӨӨ/ЛОГО график зураглал практик

ЗӨВЛӨГӨӨ:

1. Лого нь тухайн хэрэгжүүлж буй улсын соёлын онцлогт тулгуурлан төслийн ЗӨВЛӨГӨӨ/ЛОГО график зураглал практик зөвлөгөө
2. Лого нь хог хаягдлыг ангилан ялгах талаарх төслийг хялбараар ойлгоход туслах, хог хаягдлыг ангилан ялгахад хялбар ойлгомжтой байхад туслах зорилготой.
3. Лого нь хог хаягдлын ангилан ялгах төслийг шууд таних тэмдэг юм. Хог хаягдлыг ангилан ялгах тэмдэгтүүдэд ашигладаг классик өнгөнүүдээс ашигласнаар иргэдэд илүү хялбар ойлгомжтой, шууд таних боломжтой (боломжтой бол үндэсний болон олон улсын дүрэм, холбоодын зааврыг баримтлах) бөгөөд уншихад хялбар үсгийн фонт сонгох хэрэгтэй. Бүх төрлийн хэвлэмэл материал, сурталчилгааны самбар болон хүнсний баглаа боодол дээр нэгдсэн журмаар, нэг стандартыг барин хэвлэх шаардлагатай.
4. Пиктограмм ашигласнаар зааврыг ойлгоход хялбар ойлгомжтой байдаг.
5. Гарын авлага бэлтгэснээр логоны дизайны бүх элементүүдийг хэрхэн зөв таних болон хэрхэн зөв ашиглах талаар заавар өгөхөд шаардлагатай юм.
 - Логог хэвлэхэд тохиромжтой үлдээх зай – Лого харагдах байдлыг харгалзах
 - Логоны хамгийн жижиг хэмжээг тодорхойлох – Харагдах байдлыг харгалзах
 - Өнгөний кодыг тодорхойлох
 - Боломжит өнгөний хувилбаруудыг тооцоолж, алдаанаас зайлсхийх





Зааварчилгаа N°2 / Техникийн ажилтнуудад зориулсан чадавхийг бэхжүүлэх процессийг хэрэгжүүлэх

Түвшин: Хүнд

Шаардагдах хугацаа: 2 жил

Шаардагдах зүйлс: Хүний нөөц, процесс, зорилго

Заавар: Орон нутгийн засаг захиргааны техникийн ажилчид, албан хаагчид, эрдэмтэд

Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) гэдэг нь байгууллагат одоогийн нийгмийн хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд дасан зохицож, хөгжихөд шаардлагатай үр чадвар, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд, хөгжүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Шинэ технологийг нэвтрүүлэхтэй зэрэгцэн шууд удирдах хүмүүст зориулсан сургалт явуулах нь байгууллагын чадвар, үйл ажиллагааны журам, процессуудыг сайжруулах, холбогдох салбаруудын байгууллагын соёлыг хөгжүүлэх, мөн ирээдүйн зорилго, стратегийг тодорхойлох зэрэг шинэчлэлийг эхлүүлэхэд тусална. Чадавхийг бэхжүүлэх (capacity building) сургалтын шууд үр дагавар нь голчлон байгууллагын ажилтан болон байгууллагын чадвар, техникийн үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байдаг бол, шууд бус үр дагавар нь хамтын ажиллагааны төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны үнэлэмжийг нэмэгдүүлэх, түүнийг нийгмийн түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэдэг.

Ажилын явц:

Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) хөтөлбөрийн стратегийн сургалтын зорилгыг тодорхойлох.

- Шинэ технологийг нэвтрүүлэх явцад оролцох техникийн ажилчид, мэргэжилтнүүд, засаг захиргааны ажилчдыг томилох.
- Нэвтрүүлэх технологийн онолын дэвшил, технологийг тодорхойлох.
- Технологийг нэвтрүүлэх сургагчид болон хүлээн авах ажилчдын хооронд итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хангалттай өргөн хүрээний ажилын хөтөлбөр боловсруулах.
- Онлайн болон танхимын сургалт, 2 төрлийн уулзалтыг ээлжлэн зохион байгуулах.
- Хөтөлбөрийн хүрээнд оролцогчдын идэвхтэй оролцоог дэмжих, туршлага судлах зорилгоор газар дээр нь очиж үзэх хөтөлбөрүүдийг багтаах.
- Хөтөлбөрт оролцогчдын хооронд танилцах, харилцаа үүсгэх боломжтой энгийн хөтөлбөрүүдийг оруулах.

3R4UB төслийн хүрээнд шинэ технологи болон түүний арга барилыг Монгол Улсын Нийслэлийн байгаль орчны үйлчилгээний салбарт ажиллаж буй албан хаагчид, мэргэжилтнүүдэд нэвтрүүлэхэд чиглэсэн юм. Энэхүү төсөл нь орон нутгийн байгууллагуудыг чадавхжуулах зорилготой бөгөөд албаныханд хотын хог хаягдлыг нэгтгэн зохицуулсан байдлаар удирдах, үйлчилгээг Европын стандарт, технологи, байгууллагын шаардлагад нийцүүлэх, мөн тогтвортой хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Тус хөтөлбөрт 13 техникч, албан хаагч оролцсон бөгөөд тэдний дунд Нийслэлийн газар, төрийн өмчит компани болон Монгол улсын Байгаль орчны яамны ажилтнууд багтсан. Сургалтын эцэст оролцогчдын ихэнх нь өдөр тутмын үйл ажиллагаанд шууд ашиглах боломжтой практик үр чадваруудыг эзэмшсэн болно. Сургалтын арга барил нь практик үйл ажиллагаанд төвлөрсөн ба Европын туршлагын талаарх кейс судалгаа, практикыг Улаанбаатар шиг хурдацтай хөгжиж буй хотын орчинд хэрэгжүүлэх боломжтой хэлэлцүүлгүүдийг багтаасан байв. Төслийн хугацаанд зохион байгуулагдсан онлайн уулзалтууд нь Европ, Монголын түншүүдийн дунд нийтлэг техникийн ойлголт бий болгох, салбарын тэргүүлэх чиглэлүүдийг илүү үр дүнтэй хэлэлцэх, ойлгох боломжийг олгосон юм.

Товчхондоо:

Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) нь 3R4UB төслийн ерөнхий стратегийн гол хэсэг юм. Технологи нэвтрүүлснээр хог хаягдлыг илүү зохион байгуулалттай, дахин боловсруулан ашиглах дэвшилтэт технологид шилжүүлэх зорилготой юм. Үүгээр орон нутгийн чадавхийг хөгжүүлэх, үйл ажиллагааг үр дүнтэй болгох, дэвшилтэт технологийг үе шаттай хэрэгжүүлэхэд чиглэсэн.


Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) хөтөлбөрийн эхний үе шат нь зөвхөн онлайн хэлбэрээр явагдсан бөгөөд энэ нь Монгол улсын техникийн ажилчдыг газар зүйн болон логистикийн байрлалаас үл хамааран бүх хүнийг оролцуулах боломжийг олгосон. Интерактив сургалтын модул, вэбинар болон алсын зайны ажилын үеэр хотын хатуу хог хаягдлыг удирдах техникийн болон хууль эрх зүйн асуудлыг Европын жишгийн дагуу дэлгэрэнгүй судалсан.

- Хог хаягдлын асуудлаар Европын Холбооны хууль эрх зүйн хүрээ, ялангуяа 2008/98/ЕС тоот зөвлөмж болон “Тойрог эдийн засгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд” онцгой анхаарал хандуулсан.
- Байгаль орчны нийтийн үйлчилгээний удирдлагын загварууд болон стратегийн төлөвлөлтийн арга барил;
- Хог хаягдлыг ангилан цуглуулах технологи, түүнчлэн Үйлдвэрлэгчийн Өргөтгөсөн Хариуцлагын (YOX) системийн ач холбогдол;
- Хог хаягдлын төрөл тус бүрийн дахин боловсруулах болон боловсруулалтын байгууламжийг төлөвлөх, зохион байгуулах, удирдах үйл ажиллагаа;
- Салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх санхүүгийн хэрэгслүүд болон төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны механизм.

Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) хөтөлбөрийн хоёр дахь үе шатны хүрээнд Итали улсад техникийн айлчлал зохион байгуулсан бөгөөд энэ нь сургалтын явцад олж авсан мэдлэгийг бодит нөхцөлд бататгах, Европын загваруудыг шууд ажиглан туршлагауудыг нутагшуулах зорилготой байв. Хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлын менежментийн байгууламж, хог хаягдлын менежментийн чиглэлээр тэргүүлэх төвүүд, судалгааны лабораториуд, төрийн өмчит компаниуд, орон нутгийн засаг захиргааны бүтцүүдээр зочилох судалгааны аялал хэлбэрээр зохион байгуулагдсан. Айлчлалын үеэр Монголын техникийн мэргэжилтнүүд дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг автомат ангилан ялгах үйлдвэр, органик хаягдлын компостжуулалт ба анаэроб боловсруулалтын байгууламж, мөн үлдэгдэл хог хаягдлаас эрчим хүч гарган авах системүүдтэй танилцсан болно. Онцгой сонирхол татсан технологи нь Ачерра хотын дулааны аргаар хог хаягдлыг боловсруулах байгууламжийн (термовалоризатор) айлчлал байсан бөгөөд энэхүү үйлдвэр нь байгаль орчны аюулгүй байдал, эрчим хүчний үр ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг хослуулсан нэгдмэл системийн тод жишээ юм.

Зөвлөгөө/ Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд зориулсан ЗӨВЛӨМЖҮҮД:

1. Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хөтөлбөрийн хүрээнд шаардлагад нийцсэн, хөтөлбөрийн зорилтот байгууллага болон албан хаагчдыг хамруулах хэрэгтэй.
2. Шинэ технологийг нэвтрүүлэх үйл явцын зорилго болон сургалтын арга зүйг тухайн хүлээн авагч байгууллагуудын бодит хэрэгцээ, чадавхи, нөхцөл байдалд нийцүүлэн тодорхойлох нь маш чухал.
3. Онлайн болон танхимын сургалтыг ээлжлэн явуулах сургалтын хөтөлбөрийг гаргах. Танхимын сургалт нь бүх оролцогчдын дунд итгэлцэл, хамтын ажиллагаа, туршлага солилцоог дэмжих ёстой.





Зааварчилгаа №3 / Хакатон зохион байгуулах

Түвшин: Дунд зэрэг

Хугацаа: 3 сар

Эвентийн үргэлжлэх хугацаа: 24-48 цаг тасралтгүй (онлайн эсвэл хосолмол)

Шаардагдах зүйлс: Тав тух хангасан танхим, сайн холболттой Wi-Fi, хоол, уух зүйлс, кофе, амарч болох тав тухтай газар.

Үндсэн элементүүд: самбар, тэмдэглэгээ, санал бодлоо солилцох хуудас, дижитал хамтын ажиллагааны платформууд (жишээ нь, Google Workspace), нээлттэй өгөгдлийн хүртээмж

Чадавхийг бэхжүүлэх (Capacity building) гэдэг нь байгууллагат одоогийн нийгмийн хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд дасан зохицож, хөгжихөд шаардлагатай үр чадвар, байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд, хөгжүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа юм. Шинэ технологийг нэвтрүүлэхтэй зэрэгцэн шууд удирдах хүмүүст зориулсан сургалт явуулах нь байгууллагын чадвар, үйл ажиллагааны журам, процессуудыг сайжруулах, холбогдох салбаруудын байгууллагын соёлыг хөгжүүлэх, мөн ирээдүйн зорилго, стратегийг тодорхойлох зэрэг шинэчлэлийг эхлүүлэхэд тусална. Чадавхийг бэхжүүлэх (capacity building) сургалтын шууд үр дагавар нь голчлон байгууллагын ажилтан болон байгууллагын чадвар, техникийн үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байдаг бол, шууд бус үр дагавар нь хамтын ажиллагааны төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны үнэлэмжийг нэмэгдүүлэх, түүнийг нийгмийн түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэдэг.

Ажилын явц:

Уралдааны сорилтын зорилгыг тодорхойлж, оролцох оролцогчдыг сонгох (ихэвчлэн програм хангамж хөгжүүлэгчид, программистууд, график дизайнерууд, мөн сорилттой холбоотой салбарын оюутнууд болон бусад мэргэжилтнүүд) мөн шаардлагатай бол насны ангилалыг тогтоох. Уралдааны сорилтын зорилгыг зөв тодорхойлж, буруу ойлголт өгөхөөс сэргийлэх хэрэгтэй. Уралдааны зохион байгуулалтыг төлөвлөхдөө бүтээлч сэтгэлгээг төрүүлэх, оролцогчдод тав тухтай байх нөхцлийг бүрдүүлэх, (их сургуулийн орчин үеийн лекцийн танхим, дундын оффис гэх мэт) тав тухтай орчинд байрлуулахыг анхаарна уу. Хоол, уух зүйл, кофе, мөн амарч болох нам гүм газар бэлтгэх. Найдвартай Wi-Fi холболтоор хангах. Самбар, маркер, санаа бодлоо цуглуулах хуудсаар хангах. Хамтран ажиллах дижитал платформуудыг ашиглахад дэмжлэг үзүүлэх. Багийн менторуудыг сонгох, менторууд нь төслийн үйл ажиллагаанд аль хэдийн оролцсон хүмүүс байх нь зүйтэй. Багууд болон менторуудын хооронд санаа бодлоо солилцох боломжийг нэмэгдүүлэхээр төлөвлөгөөт завсарлага гаргах. Менторууд нь багууд дотор болон багуудын хооронд пич (pitch) ашиглан мэдээлэл солилцохыг дэмжвэл сайн. Шүүгчдид нь уралдаанаас гарах шийдлийг сонгохоос гадна тухайн шийдэл нь төслийн хэрэгжилт, хэрэглэгчид болон хамтрагч байгууллагуудад хэр хүртээмжтэй, үр ашигтайг харгалзан үзэх сайтар бэлтгэгдсэн, зөв бүрэлдэхүүнээр бүрдүүлэх хэрэгтэй.

3R4UB төсөл нь “3Rconthackt4UB” нэртэй хоёр хакатоныг зохион байгуулсан бөгөөд хоёулаа хог хаягдлыг ангилан ялгахад чиглэсэн байв. Эхний уралдааны сорилт нь “Экологийн сургуулийн иж бүрдлийг бий болгох аналог, дижитал эсвэл холимог шийдлүүдийг боловсруулах” байсан бол хоёр дахь удаагийн тэмцээн нь “Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг сурталчлах, урамшуулах аппликейшн эсвэл интеграцчилсан шийдэл боловсруулах”

байсан юм. “3Rconthackt4UB”-ын хоёр удаагийн тэмцээнд оюутан, салбар салбарын мэргэжлийн хүмүүс оролцсон бөгөөд сүүлийн тэмцээнд программ хөгжүүлэгчид, график дизайнерууд, маркетер (харилцаа холбооны мэргэжилтнүүд), байгаль орчны мэргэжилтнүүд, сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн судлаачид зэрэг олон талт туршлагатай хүмүүс байв. “3Rconthackt4UB” тэмцээний хоёр дугаар хоёулаа “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн байранд 40 цаг тасралтгүй үргэлжилсэн. Тэмцээний үеэр оролцогч багуудад техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор менторын хувиар хотын захиргааны мэргэжилтнүүд болон гадны мэргэжилтнүүд оролцсон. Шүүгчдийн бүрэлдэхүүнд төсөлд оролцсон захиргааны төлөөлөгчид, төслийн технологийн түнш байгууллагын төлөөлөгчид, академик болон бизнесийн салбарын төлөөлөгчид байсан болно. Эхний сорилтоос төсөлд оролцох сургуулиудад тараах зориулалттай Эко Сургуулийн Кит шийдэл гарсан.

Товчхондоо:

Хакатон нь төслийн хэрэгжүүлсэн сорилтуудын дунд сонгогдсон багуудын хооронд хамтын ажиллагааг хөгжүүлэх үр дүнтэй, шинэлэг арга юм. Уралдааны зарчим дээр тулгуурлан зохион байгуулагдсан Хакатон нь голчлон залуу мэргэжилтнүүдэд чиглэгдсэн бөгөөд уралдаант, өрсөлдөөнт орчин нь тэдний оролцоог идэвхжүүлдэг юм.

“3Rconthackt4UB” 2 удаагийн уралдаан нь дараах зорилгуудыг агуулсан болно:

- “Тогтортой хөгжлийн” зарчмуудыг дэлгэрүүлэх. Хакатоны эхний уралдаан нь залуучуудыг үйлчилгээний энгийн “хэрэглэгч”-ээс экологийн шилжилтийн идэвхтэй оролцогч болгон хувиргасан. Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгах талаарх мэдээлэл, өгөдлийг ашиглан тэд эцсийн бүтээгдэхүүндээ тойрог эдийн засаг, байгаль орчныг хамгаалах зарчмуудыг илүү үр дүнтэйгээр шингээсэн бөгөөд энэ нь ямар ч танхимын лекцээс илүү үр дүнтэй байсан. Тэмцээний эхний үе шатанд шүүгчдэд эцсийн танилцуулгыг боловсронгуй
- болгох зорилгоор танилцуулга хийхэд бэлтгэх питч уулзалт зохион байгуулсан. Бодит шийдлүүдийг бий болгох: Хоёр дахь уралдааны үеэр оюутнууд болон мэргэжилтнүүд тусад нь хог хаягдлыг цуглуулах үйл явцыг илүү ашигтай болгох, буруу ангилалыг багасгах, бууруулах дахин боловсруулах харьцааг нэмэгдүүлэх технологийн болон бүтээлч шийдлүүдийг (аппликейшн, платформ, харилцаа холбооны кампанит ажил, тоглоомчлол) боловсруулсан.

Төслийн зорилгын дагуу, шагналыг зөвхөн мөнгөн хэлбэрээр гардуулахаас гадна 3Rconthackt4UB”-ийн анхны уралдааны ялагч багт тэмцээний үеэр танилцуулсан туршилтын загварыг бодитоор хөгжүүлэх боломжийг олгосон.

“3Rconthackt4UB” уралдаан бүрийн хувьд ялангуяа залуу хэрэглэгчдэд хүрэхийн тулд тэмцээнийг сурталчилах, мэдээлэх үйл ажиллагаа нь маш чухал байсан. Төсөл нь уралдаан болон тэмцээний элементүүд онцгой анхаарч, уралдааны мэдээлэл, сурталчилгаанд дараах аргуудыг ашигласан. Үүнд:

- Залуусын сувгууд: Уралдааныг сайн сурталчлахын тулд залуусын дунд хамгийн өргөн хэрэглэгддэг сошиал платформууд (Facebook, Instagram) ашиглагдсан. Сурталчилгаанд шинэлэг, эрч хүчтэй харилцааны хэв маяг оруулсан.
- Түүх өгүүлэх (storytelling): Уралдааны хоёр хувилбарыг бодитоор цацсан. Ихэвчлэн тусгай hashtag (жишээ нь #3Rconthackt4UB) үүсгэх, оролцогчдын ярилцлага, менторуудын бичлэг, “хөшигний ард” (behind the scenes) болсон дүрс бичлэгүүдийг хуваалцах нь үр дүнтэй байсан. Энэ нь иргэдийн сонирхлыг нэмэгдүүлж, тэмцээний үр дүнг өсгөдөг.
- Логог сурталчилах: Уралдаан зохион байгуулагч байгууллагуудын лого болон хог хаягдлыг ангилах ялгах төслийн логотой холбон сурталчихах нь зүйтэй. Төрийн байгууллагуудын оролцоог илүү харуулснаар илүү итгэл, үнэмшил төрүүлдэг.

Зөвлөгөө/ Хакатоныг амжилттай зохион

байгуулахад зориулсан практик зөвлөмжүүд:

1. Тэмцээний логистикийн бэлтгэл нь Хакатоныг амжилттай болоход нөлөөлсөн гол хүчин зүйл юм. Зохион байгуулах тохиромжтой байр сонгох, тэмцээний зохион байгуулалтыг сайтар төлөвлөх, оролцогчдод биеийн болон сэтгэлийн тавтхыг хангах нь багуудыг сорилтоо шийдвэрлэхэд бүрэн төвлөрөх боломжийг олгодог.
2. Үр дүнг урьдчилан тооцоолон (output) тодорхойлсон байх шаардлагатай: аппликейшн прототип, боловсролын тоглоомын загварууд, мэдлэг түгээх кампанит ажлын концепт гэх мэт.
3. Тэмцээний зохион байгуулагчид хамгийн ирээдүйтэй туршилтын загваруудыг туршиж, баталгаажуулах, сонгосон шийдлүүдийг бодитоор хөгжүүлэх зэрэг тэмцээний дараагийн ажлуудыг нэн тэргүүнд тавих ёстой.
4. Хакатонд оролцогчдод, ялангуяа ялагчдад олон нийтийн сэтгэлд хүрсэн шагнал өгөх нь төсөл болон түүнийг дэмжиж оролцсон байгууллагууд, мөн тэмцээнтэй холбоотой орон нутгийн, нийгмийн болон мэргэжлийн бүх хүрээг шууд таниулах чухал боломж юм.





Зааварчилгаа N°4 /Мастер төлөвлөгөө боловсруулах

Түвшин: Өндөр

Шаардагдах хугацаа: 18 сар

Шаардлагатай зүйлс: Өгөгдлийн сан, өгөгдөл боловсруулах, Баталгаажуулах

Үндсэн элементүүд: Сэдэвчилсэн болон шинэчлэгдсэн өгөгдлийн багц, гол үзүүлэлтүүд, техникийн болон салбарын мэргэжилтнүүд, нийгмийн болон зорилтот бүлгүүд, GIS орчинд ажиллах боломжтой програм хангамж.

Мастер төлөвлөгөө нь хотын хог хаягдлын тогтвортой менежментийн эдийн засгийн хэмнэлт, ашиг, үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэх гол хэрэгсэл юм. Ерөнхийдөө, мастер төлөвлөгөө гэдэг нь тодорхой нутаг дэвсгэр эсвэл үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн чиглэл, зорилтыг тодорхойлсон стратегийн баримт бичиг бөгөөд хэрэгжилтэд оролцох байгууллага, талуудыг тодорхойлохын зэрэгцээ боломжит санхүүжилтийн эх үүсвэр, ашиглагдах арга хэрэгсэл, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хугацааг тусгадаг. Мастер төлөвлөгөө нь заавал даган мөрдөх хууль эрх зүйн баримт биш бөгөөд дотоод зааварчилгааны хэсэгт ордоггүй. Мастер төлөвлөгөө нь олон нийтийн болон хувийн хэвшлийн бүх оролцогч талуудын хооронд байгуулсан институцийн “гэрээ” буюу харилцан ойлголцлын үндсэн дээр хэрэгждэг бөгөөд нөхцөл байдал өөрчлөгдөхөд өөрчлөлт оруулах боломжтой баримт бичиг юм. Мастер төлөвлөгөө нь хууль эрх зүйн чадамжгүй бөгөөд төслийн зорилтуудтай уялдсан үйл ажиллагааг тодорхойлохын зэрэгцээ оролцож буй нийгмийн бүлгүүдийг харгалзан мастер төлөвлөгөөг боловсруулдаг.

Ажилын явц:

Мастер төлөвлөгөөг боловсруулахын өмнө тухайн хот болон нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг харгалзан анализ хийх нь чухал юм. Энэ үе шатанд төлөвлөгөөний чиглэл, тодорхой зорилтуудыг тодорхойлохын зэрэгцээ, төсөл боловсруулах үйл явцад оролцох гол нийгмийн бүлгүүд, тэр дундаа төрийн байгууллагуудыг тодорхойлж, оролцуулах шаардлагатай. Гол зургыг гаргасны дараа төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээг тодорхойлж, хог хаягдал ангилан цуглуулалгын салбарт зориулсан тусгай өгөгдлийн сангуудыг сонгоно. Үүний зэрэгцээ өгөгдлийн чанар болон найдвартай байдлыг нь шалгах хэрэгтэй. Сценари дээр суурилсан төлөвлөгөөний аргууд ашиглах нь үр дүн, үр ашиг болон зардлыг хялбар аргаар харьцуулах боломжийг олгодог. Энэ нь хариуцагч байгууллагууд, мөн оролцогч нийгмийн бүлгүүдэд хамтран шийдвэр гаргах, ухаалаг сонголт хийх боломжийг олгодог. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг тодорхой оруулах ёстой: төслийн нутаг дэвсгэрийн нөхцөл байдал; цуглуулгын зорилт болон төслийн хугацаа; төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай биет болон биет бус хөрөнгө; мөн шаардлагатай тоног төхөөрөмж, үйлчилгээ (үйлчилгээний төрөл, хэмжээ, багтаамж). Хяналтын хөтөлбөр нь төлөвлөгөөг бүрдүүлж, зорьсон зорилтуудын биелэлтийг амжилтай хэрэгжүүлсэн эсэхийг шалгахад тусална.

3R4UB Мастер төлөвлөгөө нь олон салбарт чиглэгдсэн тоомоохон стратегийн төсөл бөгөөд энэ нь олон шаттай, олон түвшинд хэрэгжих зорилготой. Энэхүү төслийг богино, дунд, урт хугацаанд хийхээр төлөвлөсөн болно. Мастер төлөвлөгөө нь гурван үндсэн хэсэгтэй бөгөөд тус бүр дараах байдлаар хийгдсэн болно:

1. Тандалтын судалгаа ба мэдлэгийн үе: Улаанбаатар хотод үүсдэг хог хаягдлын тоо хэмжээ, төрөл зүйлийн талаарх мэдээлэл олж авахад чиглэгдсэн. Энэ нь төслийн хүрээнд газар нутгийг судалж, хог хаягдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах үе юм.

2. Зорилго, зорилтыг тодорхойлох: Тандалтын судалгааны үр дүнд гарсан мэдээллэлд үндэслэн, зорилго, зорилтыг тодорхойлох. Энэ шатанд төслийн стратегийн зорилго, чиглэлийг тодорхойлон, уг зорилгод нийцсэн баримт бичгийг боловсруулах юм.

3. Стратегийн зорилго, зорилт тодорхойлох: Энэ шат нь, өмнөх үе шатуудад гарсан зорилтуудыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, Улаанбаатар хотын бүс нутаг, хороод тус бүрийн онцлогт тохируулан стратегийн зорилтууд болон түүнд нийцсэн зорилтуудыг боловсруулах юм. Төлөвлөгөөний стратегийн зорилтууд нь: Хог хаягдлыг айл өрх бүрийн түвшинд ангилан ялгах үйл явцыг сайжруулах; Органик хогийг боловсруулах компост болон анаэробын боловсруулалтын үйлдвэрүүдийг байгуулах; Пластик, цаас, металл зэрэг хог хаягдлыг нарийвчилсан ангилалт хийх дэвшилтэт байгууламжуудыг хөгжүүлэх; Хог хаягдлаас эрчим хүч гарган авах; Хог хаягдлыг дахин боловсруулах орон нутгийн зах зээлд эргүүлэн нийлүүлэх зорилгоор бүсчилсэн циркуляр төвүүдийг байгуулах.

Товчхондоо:

3R4UB мастер төлөвлөгөө нь Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг тогтвортой байдлаар хянах стратегийн төлөвлөгөө буюу “гол зураг” юм. Баримт бичигт хүн ам зүйн шинжилгээ, хог хаягдлын хэмжээ ба найрлагын талаарх өгөгдөл, 2035 он хүртэлх хөгжлийн таамаглал, бодлогын чиглэлүүдийг нэгтгэн тусгасан. Төлөвлөгөөний үндсэн зорилго нь хог хаягдлыг шууд булшлах хэмжээг бууруулахын зэрэгцээ Европын Холбооны дэвшүүлсэн “Тойрог эдийн засгийн зарчмуудтай” нийцсэн менежментийн тогтолцоог бий болгоход оршино.

3R4UB мастер төлөвлөгөө нь Улаанбаатар хотод хог хаягдлыг тойрог эдийн засгийн зарчимд нийцүүлэн удирдах гол суурь нь юм. 2035 оны хувилбарууд нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэгчийн хариуцлагын бодлогыг өргөжүүлэх, иргэдийн идэвхтэй оролцоотойгоор дамжуулан гаргасан том төсөлүүд боловч биелэх боломжтой зорилтууд юм. Хог хаягдлыг ангилан ялган цуглуулахад зориулсан 2035 он хүртэлх гурвалсан төлөвлөгөөт хувилбар боловсруулсан болно: Үндсэн хувилбар – 50% ялгалт; Дунд хувилбар – 60% ялгалт; Дэвшилтэт хувилбар – 70% ялгалт. Хог хаягдлыг булшлах хэмжээг шат дараалан бууруулах нь хотын байгаль орчны тогтвортой байдал, нөхөн сэргээгдэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

Зөвлөгөө / Мастер төлөвлөгөө амжилттай

боловсуурах практик зөвлөмжүүд:

1. Системийн үр ашигтай ажиллагааг хангахын тулд мастер төлөвлөгөө нь Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын системийг байгуулах, хяналт шалгалтын механизмийг сайжруулах, мөн Европын Холбооны хог хаягдлын заавар (2008/98/ЕС) ба Тойрог эдийн засгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцсэн хууль эрх зүйн чадамжуудыг нэвтрүүлэх шаардлагатайг онцолж байна.
2. Мастер төлөвлөгөөнд түүнийг хэрэгжүүлэх хугацаа, тус бүрийн үйл ажиллагаанд шаардлагатай нөөц, хариуцагч талуудыг тодорхой зааж өгөх ёстой бөгөөд мөн хууль эрх зүйн орчин болон төлөвлөгөөнд заасан хугацааг харгалзан үзэх шаардлагатай.
3. Төсөл, арга хэмжээнүүдийг агуулга болон хугацааны хувьд харилцан уялдуулах шаардлагатай ба оролцогч талуудын хувьд гэрээ байгуулан зохицуулна.
4. Судалж буй бүс нутгийн болон тухайн орны нийгэм, эдийн засгийн мэдээллийг товч дүгнэх нь чухал.





Зааварчилгаа N°5 /Санхүүжилт

Түвшин: Дунд

Шаардагдах хугацаа: 24 сар

Шаардагдах зүйлс: Төрийн санхүүжилт, Хамтарсан хөрөнгө оруулалт, Хувийн хөрөнгө оруулалт, Орлогын дахин хөрөнгө оруулалт.

Үндсэн элементүүд: Төр-хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ), Ногоон бонд ба тогтвортой санхүүжилт, Байгаль орчны тариф ба Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага, Төр, хувийн хэвшлийн холимог санхүүжилт.

Тойрог эдийн засаг нь хөгжлийн стратеги төдийгүй санхүүгийн эх үүсвэр юм. Хог хаягдлын менежментэд шилжих нь уламжлалт “цуглуулах, ангилах, булшлах” загварыг дахин ашиглагдах материал, сэргээгдэх эрчим хүч болгон ашиглах боломжтой. Тойрог эдийн заса руу шилжихэд хөрөнгө босгох, эрсдлийг хуваалцах чадвартай санхүүгийн мэдлэг болон хог хаягдлыг дахин ашиглах байнгын, тасралтгүй эргэлтэнд оруулах чадвартай бизнесийн байгууллагуудыг татан оролцуулах шаардлагатай юм. Үйлдвэрлэлийн байгууламж, логистик болон хяналтын системд хийх хөрөнгө оруулалт нь их бөгөөд эдийн засгийн үр өгөөж нь удаан хугацааны дараа гардаг. Тиймээс зөвхөн технологи болон хууль эрхзүйн орчинг зохицуулахаас гадна санхүүгийн зохицуулалт ч мөн маш чухал.

АЖИЛЫН ЯВЦ:

Төслийн санхүүжилтийг шийдэхийн тулд төсөл хэрэгжих газрын нийгэм, эдийн засгийн онцлог, техникийн байдал, болон оролцогч талуудын боломжид тохирсон олон төрлийн, уян хатан шийдэл бүхий систем шаардлагатай. Энэхүү шийдлийг олохын тул “Хотын Тойрог эдийн засгийн төсөв, (Circular urban fund)” байгуулах хэрэгтэй бөгөөд тус төсөв нь хог хаягдлын менежментеер бий болсон орлого, ашигийг дахин нийгэмд чиглэсэн төслүүдэд хөрөнгө оруулах тойрог эдийн засгийн тогтолцоо юм. Хотын тойрог эдийн засгийн төсөв (CUF) нь төр-хувийн хэвшлийн түншлэл, тогтвортой санхүүжилт (ногоон бонд), байгаль орчны тариф болон үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага, төрийн болон хувийн сангуудын хоорондын схемийг хослуулан, бүтцийн хөрөнгө оруулалт болон аж үйлдвэрийн инновацийг дэмждэг.

3R4UB төслийн Мастер төлөвлөгөө нь төр, хувийн хэвшлийн түншлэл, тогтвортой санхүүжилт (ногоон бонд), байгаль орчны тариф болон үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага, төрийн болон хувийн сангуудын хоорондын схемийг хослуулан, бүтцийн хөрөнгө оруулалт болон аж үйлдвэрийн инновацийг дэмжих “Хотын тойрог эдгийн засгийн төсвийг” (CUF)-ийг нэвтрүүлэв. 3R4UB төсөл нь “Тойрог бизнесийн инкубацийн санаачилга” (Circular Business Incubation Initiative)-г эхлүүлсэн бөгөөд үүнд: Микросанхүүжилт (5–10 мянган евро), Бизнесийн загварын зөвлөгөө, Дахин боловсруулсан материалын нийлүүлэлтийн сүлжээнд хандах боломж зэрэг орсон болно. 3R4UB төслийн хүрээнд Европын Комиссын хөрөнгө оруулалтанд орсон 1 евро бүрийг ажлын байр бий болгох, хог хаягдлыг устгах зардлыг хэмнэх, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт оруулсан бөгөөд тооцоогоор 2,6 евроны ашигтай байна. Хөрөнгө

оруулалтыг шийдэх боломжтой аргуудаас дурдвал: Европын Холбооны SWITCH-Asia хөтөлбөрийн санхүүжилтийн уралдаан (2026–2028), Азийн Хөгжлийн банк (АХБ) ба Европын сэргээн босголт хөгжлийн банкийн (ЕСБХБ) хамтарсан санхүүжилт – хог хаягдлыг дахин ашиглах төсөлд зориулсан санхүүжилт, НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО) ба НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) -ийн тэтгэлэг – ЖДҮ-ийг ногоон болгох санаачилгад дэмжлэг үзүүлэх, Итали улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны (AICS) техникийн түншлэлүүд зэрэг байж болно. Энэхүү аргаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжил болон байгаль орчны үр ашгийг дэмжих зорилготой юм.

Товчхондоо:

ЕСО-UB загвар нь хог хаягдлын менежмент дэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) хэрэгжих боломжтой хөтөлбөрүүдийг танилцуулж байна. Тухайлбал, ТХХТ, ногоон бонд, байгаль орчны тариф/үйлвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага, төр болон хувшлийн холимог санхүүжилт нь эдийн засаг, үйлдвэрлэлийн хүрээнд дараах нөлөөг үзүүлдэг: Энэ нь дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хурдасгах, дахин боловсруулалтын шинэ нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, мэргэжлийн ажлын байр бий болгох, үйлчилгээний эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулах зэрэг юм. 3R4UB төсөл нь төр-хувийн хэвшлийн түншлэл, тогтвортой санхүүжилт (ногоон бонд), байгаль орчны тариф болон үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага, төрийн болон хувийн хэвшлийн схемийг хослуулахыг дэмжиж, бүтцийн хөрөнгө оруулалт болон аж үйлдвэрийн инновацийг дэмждэг. 3R4UB төслийн туршлагаар хөгжиж буй хотод хэрэгжүүлэх боломжтойг харуулж байгаа ба үүний үр дүнд байгаль орчны нөхөн сэргээлж нэмэгдэж, хувийн хөрөнгө оруулалт татах бололцоог сайжруулах боломжтой.

3R4UB-ийн олон тулгуурт хандлага нь дэд бүтцийг богино хугацаанд байгуулах, хөрөнгө оруулагчдын эрсдэлийн үнэлгээг багасгах, дахин ашиглах эдийн засгийн эргэлтийг дэмжихийн тулд ашигладаг. Үүнд:

- Төр, хувийн хэвшлийн түншлэл нь төлөвлөлт, барилга угсралт, ашиглалт, үйл ажиллагааны менежментийг (DBO/BOT хэлбэрээр) хувийн хэвшлийн байгууллагад даатгах боломжийг олгодог бөгөөд энэ нь улсын төсөвт дарамт учруулахгүйгээр менежментийн үр ашиг, эрт хөрөнгө оруулалтыг баталгаажуулдаг. Эрсдэлийн хуваарилалтыг гэрээгээр зохицуулах ба гэрээг тухайн төслийн гүйцэтгэл, үйлчилгээний чанар мөн объектын ашиглалтын боломжтой уялдуулан хийнэ.
- Ногоон бонд нь байгаль орчны төслийг санхүүжүүлэх хэрэгслийн нэг бөгөөд нөхөн сэргээх төслүүдэд (дахин боловсруулах байгууламж, хог хаягдлын дижитал хяналт, эрчим хүч сэргээх болон биогаз, компост үйлдвэрлэл) орлогыг дахин хувиарлах. Ногоон бондууд нь төслүүдийн санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, институцийн болон Байгаль орчин, нийгмийн чиглэлд хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлдэг.
- “Pay-as-you-throw” хэрэглээнийхээ хэрээр төлөх зарчмаар тогтоосон төлбөр болон Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын (Extended Producer Responsibility) системүүд нь байнгын тогтвортой орлогын тогтолцоог үүсгэж, иргэдийг болон бизнес эрхлэгчдийг эрүүл, зөв дадалдуриалдаг. Энэ нь зардлыг хаах боломжийг нэмэгдүүлж, төрийн төсвөөс харах хамаарлыг багасгах, хог хаягдалыг дахин боловсруулах тогтолцоог сайжруулах үр нөлөөтэй.

- Blending буюу холимог санхүүжилт нь тэтгэмж (grant), хөнгөлөлттэй зээл, хувьцаа (equity), тарифын хувь нэмэр зэрэг эх үүсвэрүүдийг нэгтгэж, төрийн төсвийг нэмэгдүүлэх зорилготой. Энэхүү арга нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж, том төслүүдийг хурдан санхүүжүүлэх, мөн шинэ, инновацлаг технологийг хэрэгжүүлэхийг дэмждэг юм.

Зөвлөгөө / Санхжүүлжилтийг тодорхойлох практик зөвлөмжүүд:

1. Тойрог дэд бүтцийг хөгжүүлэхэд олон түвшний санхүүжилт хэрэгтэй бөгөөд үүнд төрийн санхүүжилт, хувийн хөрөнгө оруулалт, олон улсын дэмжлэг шаардлагатай.
2. Хог хаягдлын салбар нь хотын циркуляр шилжилтийн эхлэл цэг юм. Хог хаягдлыг устгахаас илүү, дахин ашиглахад анхаарснаар хог хаягдлыг дахин боловсруулж болох болон компост хийх боломжтой материалыг эргэлтэнд оруулах боломжтой бөгөөд үүний зэрэгцээ шинэ ажлын байр бий болгох, сургалт оруулах замаар нийгэмд эерэг нөлөө үзүүлэх, хүлэмжийн хий бууруулах, бохирдлыг хянах замаар байгаль орчны нөхөн сэргээлтэйг нэмэгдүүлэх боломжтой.
3. Тойрог шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхэд удирдлагын арга хэмжээ чухал үүрэгтэй. Хотын эдийн засгийн хөгжлийн стратегид тойрог эдийн засгийг нэгтгэх, тойрог эдийн засгийн зохицуулалтын нэгжийг байгуулах, үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын схемийг нэвтрүүлэх, дахин боловсруулалт, нөхөн сэргээх зориулалттай эко-аж үйлдвэрийн бүсүүдийг бий болгох зэрэг орно.



switchasia



Funded by
the European Union



ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хотын
вайгалийн
нөөций
тогтвортой
ашиглах 3RҮҮД



3R4UB

Reduce - Reuse - Recycle